

“АРТКОН”  
ХХК

ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ШИЙДЭЛ



## “БИЧИЛ” ОЛОН НИЙТИЙН ТӨВ

Техник эдийн засгийн үндэслэл,  
барилгажилтын төсөл

АГУУЛГА		Хуудасны дугаар
	Зураг төсөл зохиогчдын бүрэлдэхүүн	2
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨЛӨВЛӨЛТӨД ТУСГАГДСАН БАЙДАЛ</b>		
1.1	Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	3-6
1.2	Дэд төвүүдийн хэрэгжилт	7-17
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИЙДЭЛ</b>		
2.1	Нийгэм эдийн засгийн төлөвлөлт	
2.1.1	Техник эдийн засгийн үзүүлэлт	18-19
2.1.2	Хүн амын төлөвлөлт	19
2.1.3	Орон сууцны хангамжийн төлөвлөлт	20
2.1.4	Олон нийт, үйлчилгээний хангамжийн төлөвлөлт	20
2.1.5	Ажиллах хүчний тооцоо	21
2.2	Инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт	
2.2.1	Инженерийн бэлтгэл арга хэмжээний төлөвлөлт	22-27
2.2.2	Дулаан хангамжийн төлөвлөлт	28-38
2.2.3	Цахилгаан хангамжийн төлөвлөлт	39-43
2.2.4	Ус хангамж, ариутгах татуургын төлөвлөлт	44-50
2.2.5	Холбоо, мэдээллийн сүлжээний төлөвлөлт	51-57
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО</b>		
3.1	Хөрөнгө оруулалтын нэгдсэн тооцоо	58-59
3.2	Олон нийтийн барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын тооцоо	60
3.3	Худалдаа, үйлчилгээний барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо	60
3.4	Орон сууцны барилгажилтын хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо	61
3.5	Инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын урьдчилсан тооцоо	61-64
3.6	Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	64-66

## ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Зохиогчдын нэр	Мэргэжил	Оролцсон бүлэг, хэсэг
<b>Үндсэн гүйцэтгэгч</b>			
1.	Б.Хосбаяр	Захирал, Хот төлөвлөлтийн зөвлөх архитектор, төслийн удирдагч	Архитектур, орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл
2.	Д.Жагар	Хот төлөвлөлтийн зөвлөх архитектор	Архитектур, орон зайн төлөвлөлт, концепц
3.	Д.Хишигсүрэн	Хот төлөвлөлтийн зөвлөх архитектор	Архитектур, орон зайн одоогийн байдал, гудамж замын сүлжээ, төлөвлөлтийн үндсэн шийдэл гаргах
4.	Б.Золзаяа	Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор	Одоогийн байдал, төлөвлөлтийн зураглал график гүйцэтгэл
5.	В.Жаргалсайхан	Хот төлөвлөлтийн мэргэшсэн архитектор	Одоогийн байдал, төлөвлөлтийн зураглал график гүйцэтгэл
6.	П.Мөнхбаяр	Газарзүйч, бүс нутаг судлаач	Байгаль газар зүй, хүрээлэн буй орчны хамгаалал
7.	Г.Балжмаа	Мэргэшсэн газар зохион байгуулагч	Газар ашиглалтын одоогийн байдал, төлөвлөлт, зураглал, мэдээлэл нэгдсэн санг үүсгэх
8.	Д.Бумаажав	Хот төлөвлөлтийн мэргэшсэн эдийн засагч	Эдийн засгийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, техник эдийн засгийн тооцоолол
<b>Туслан гүйцэтгэгч</b>			
9.	Г.Цэцэгмаа	Дулаан хангамжийн инженер	Дулаан хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, зураглал
10.	Д.Лхагвасүрэн Б.Даш	УХАТ-ын инженер	Ус хангамж, ариутгах татуургын одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, зураглал
11.	Ж.Эрдэнэбат М.Баасандорж	Цахилгаан хангамжийн инженер	Цахилгаан хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, зураглал
12.	Д.Мөнх-Эрдэнэ Д.Лхагвадорж	Холбооны инженер	Мэдээлэл холбооны сүлжээний одоогийн байдлын судалгаа, төлөвлөлт, зураглал
13.	И.Сайнсанаа	“Ленд тест” ХХК-ийн захирал, геологийн инженер	Инженер геологийн судалгаа дүгнэлт, зураглал
14.	Ц.Цэвэлмаа Ч.Мөнхшүр	“Эн Пи Эл” ХХК-ийн захирал, Зөвлөх инженер	Инженерийн бэлтгэл арга хэмжээний судалгаа, төлөвлөлт

# АЛСЫН ХАРАА

# 2050

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:


## БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БАЙДАЛ



### “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Улаанбаатар ба дагуул хот” дэд бүлгийн 9.3.2-т Соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, хот доторх төвлөрлийг багасгахаар тусгагдсан.

Зураг 1. Алсын хараа-2050, Олон төвт хотын тогтолцоо



Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор соёл боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн дэд бүтцийн хангамж бүхий хотын төв, дэд төв, төрөлжсөн төв, олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж олон төвт хотын тогтолцоог бүрдүүлнэ.




## УЛААНБААТАР ХОТЫН 2040 ОН ХҮРТЭЛХ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



Нийслэл хотын хэмжээнд мөрдөн ажиллаж байгаа “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Үнэлгээ дүгнэлт, суурь судалгаа”, “Концепц”, “Ерөнхий төлөвлөгөө” гэсэн 3 үе шаттай хийж гүйцэтгэж байна. Хоёр дахь үе шат болох “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-ыг боловсруулж Монгол Улсын засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн бөгөөд тус үзэл баримтлал /концепц/-ын дагуу Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж байна. Улаанбаатар хотын төлөвлөлтийн одоогийн хэв маягийг хадгалсан, оновчтой орон зайн бүтэцтэй, олон төвт хот болгон хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгагдсан.

- Улаанбаатар хотод хотын шинэ төв, дэд төвүүдийг үүсгэн байгуулж, тэдгээрийг холбосон хөгжлийн коридорыг бий болгох;
- Төрөлжсөн төв, хорооллын олон нийтийн төвүүдийг шинээр байгуулж, олон төвт хотын тогтолцоо цогцоор нь бүрдүүлэх;
- “Яармаг” хотын шинэ төвийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
- “Баянхошуу”, “Сэлбэ” хотын дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх;
- “Сонсголон”, “Шинэ төв”, “Амгалан” дэд төвүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх;
- Сайжруулсан сууцны болон орон сууцны хорооллуудад 26 олон нийтийн төвийг байгуулах;
- Худалдаа, спорт, аялал жуулчлал, эрүүл мэндийн чиглэлээр дагнасан үйлчилгээ үзүүлэх төрөлжсөн төвүүдийг байгуулах.

Зураг 2. Олон төвт хотын тогтолцоо



Эх сурвалж. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө


### Олон төвт хотын төрөл

ХОТЫН ТӨВ	ХОТЫН ДЭД ТӨВ	ОЛОН НИЙТИЙН ТӨВ	ТӨРӨЛЖСӨН ТӨВ
<ul style="list-style-type: none"> <li>▪ Их тойруу</li> <li>▪ Яармаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Баянхошуу</li> <li>▪ Сэлбэ</li> <li>▪ Сонсголон</li> <li>▪ Амгалан</li> <li>▪ Шинэ төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Дамбадаржаа</li> <li>▪ Дэнжийн мянга</li> <li>▪ Шархад</li> <li>▪ Толгойт зэрэг 26 олон нийтийн төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>▪ Авто худалдааны төв</li> <li>▪ Улиастай</li> <li>▪ Скай рисорт</li> </ul>

### Олон нийтийн төв


Оршин суугчдын нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амьдралын орчныг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халуун ус, соёл урлаг, биеийн тамирын барилга байгууламжуудыг, сайжруулсан сууцны хорооллуудын олон нийтийн төвүүдэд барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Олон нийтийн төвүүд байгуулах байршлыг үйлчилгээний хүртээмж болон хот төлөвлөлтөд тавигдах стандартын шаардлагуудад нийцүүлэн сонгох бөгөөд дахин төлөвлөлт хийж хөгжүүлнэ. Тухайн хороололд оршин суугчид нь өөрийн хөрөнгөөр орон сууцны нөхцөлөө сайжруулах бөгөөд энэ арга хэмжээнд зориулж улс, нийслэлийн зүгээс хөнгөлөлттэй орон сууцны зээлийн бодлогоор дэмжихээр тусгагдсан байна.

Зураг 3. Хотын олон нийтийн төвүүд



Эх сурвалж. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/

Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-д төлөвлөлтийн 23 дугаар нэгж хорооллын нутаг дэвсгэр Сонгинохайрхан дүүргийн 2, 3 дугаар хороо,Толгойт, Орбит орчимд олон нийтийн төв байгуулахаар тусгагдсан байна. Тус олон нийтийн төвийн байршлыг 23 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нарийвчлан тогтооно.




## 1.1 ХОТЫН ДЭД ТӨВҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” бодлогын баримт бичиг батлагдсан. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр хотын хүн амыг 2020 онд 1,534 мянга үүнээс дагуул хаяа хот тосгодод 298 мянган хүн ам оршин суухаар төлөвлөсөн байна. Мөн хотын дэд төв, дагуул, хаяа, хот тосгодыг хөгжүүлж хотын төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийг хот төлөвлөлтийн 8 бүсэд хувааж нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэхээр тусгагдсан. Төлөвлөлтийн бүсүүдэд засаг захиргаа, худалдаа үйлчилгээ, соёл боловсрол, орон сууц , олон нийт, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээ бүхий “Их тойруу” /одоогийн/, “Яармаг” /шинэ/ гэсэн 2 хотын төв , Баянхошуу, Сэлбэ, Шинэ хот, Сонсголон, Гурвалжин, Амгалан гэсэн 6 дэд төвтэй байхаар төлөвлөгдсөн.

Зураг 4. Хотын төв, дэд төвүүдийн төлөвлөлт



Эх сурвалж. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”

### ХОТЫН ТӨВ

Төр захиргаа, эдийн засаг, бизнес санхүү, мэдээлэл технологи, спорт, соёл шинжлэх ухаан, олон улсын хэмжээний үйл ажиллагаа явуулах хотын шинэ төв байна. Хотын төвд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

- Төрийн төв захиргааны байгууллагууд /УИХ, ЕТГ, МУЗГ/
- Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухааны байгууллагууд
- Олон улсын байгууллагууд
- Олон нийтийн байгууллагууд
- Бизнесийн болон бусад байгууллагууд
- Худалдаа үйлчилгээний томоохон байгууллагууд



“Бичил” олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл

- Зарим томоохон эмнэлгийн цогцолбор
- Орон сууц бүхий худалдаа үйлчилгээ

**Хотын хуучин төвд:** Монгол улсын Их Хурал, түүний тамгын газар, Монгол Улсын Ерөнхийлөгч түүний тамгын газар, зарим яамд, тусгай газрууд, бизнесийн байгууллагууд байрлана.

**Хотын шинэ төвд:** Монгол Улсын Засгийн газар, зарим төрийн яамдууд, тусгай газрууд, дүүрэг, бүсийн засаг захиргааны нэгжүүд, бизнесийн төв дүүрэг байрлана.

### **ХОТЫН ДЭД ТӨВ** /төлөвлөлтийн бүсийн төв/

Хотын дотор зохисгүй төвлөрлийг задлах төлөвлөлтийн шийдлийн хүрээнд худалдаа үйлчилгээ, соёл боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, амралт зугаалга, орон сууцны барилга байгууламжууд байхаар төлөвлөгдсөн. Мөн хотын шинээр төлөвлөгдөж буй төлөвлөлтийн бүсийн төвийн үүргийг гүйцэтгэнэ. Хотын дэд төвд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна.

- Монгол Улсын дээд шүүх, харьяа байгууллагууд
- Монгол Улсын прокурорын болон харьяа байгууллагууд
- Агентлагууд
- Дүүргийн төрийн захиргааны байгууллагууд
- Соёл урлаг, спорт олон нийт, худалдаа үйлчилгээ
- Жижиг дунд бизнесийн байгууллагууд
- Анагаах ухааны байгууллагууд
- Орон сууц бүхий худалдаа үйлчилгээ байна.

### **ХОРООЛЛЫН ТӨВ**

Хотын барилгажсан хэсэгт гол төлөв байрлана. Эдгээр төвүүд нь хотын төв, дэд төвүүдтэй, өөр хоорондоо гудамж зам, нийтийн тээврийн сүлжээгээр холбогдоно. Хорооллын төвд голлон дараах байгууллагууд байршиж үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Хороо захиргаа
- Олон нийт болон үзвэр, худалдаа үйлчилгээ
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, банк санхүүгийн байгууллага
- Үзвэр үйлчилгээ, спортын цогцолборууд
- Эмнэлэг, сургууль зэрэг байгууллагууд төвлөрч үйл ажиллагаа явуулна.

### **ОЛОН НИЙТИЙН АНХАН ШАТНЫ БИЧИЛ ТӨВ**

Гэр хорооллын амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор олон нийтийн төвийг байгуулах бөгөөд хүн амын үйлчилгээ төвлөрсөн /худалдаа, үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц/ суурьшлыг хөгжүүлнэ. Олон нийтийн төв байгуулахаар төлөвлөж буй нутаг дэвсгэрт газрыг дахин төлөвлөлтөд оруулж, газар өмчлөгч, эзэмшигч нарт нөхөн төлбөр олгох, төсөлд хамруулах журмаар газар чөлөөлж барилгажуулна. Олон нийтийн төв нь байрлаж буй талбайн онцлогтой уялдсан өвөрмөц архитектур орон зайн төлөвлөлтийн шийдэлтэй байна. Төв нь хатуу хучилттай замаар хотын бусад хэсгүүдтэй холбогдох ба нийтийн тээврийн


“Бичил” олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл

буудал зайлшгүй байх шаардлагатай. Олон нийтийн төвд гэр хорооллын иргэдийн амьдрах орчныг бүрдүүлэхэд шаардлагатай дараах барилга байгууламжууд байна. Үүнд:

- Хороо захиргаа, олон нийтийн байгууллагууд
- Жижиг дунд үйлдвэрлэл
- Худалдаа, үйлчилгээ /хүнс барааны дэлгүүр, ахуйн үйлчилгээ, халуун ус/
- Банкны салбар
- Нийгмийн дэд бүтцийн байгууллагууд /сургууль, цэцэрлэг, эмнэлэг/
- Бичил бизнес
- Дунд давхрын нийтийн орон сууц
- Инженерийн хангамжийн эх үүсвэр /уурын зуух, цэвэрлэх байгууламж, цахилгааны дэд өртөө/
- Амралт зугаалгын цэцэрлэгт талбай

## ХОТЫН ДЭД ТӨВҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Зураг 5. Хотын төв, дэд төвүүдийн хэрэгжилт



Нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд “Яармаг” хотын шинэ төв, Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн бүтээн байгуулалт хийгдэж байгаа бөгөөд дараагийн шатны дэд төв болох “Дамбадаржаа”, “Дэнжийн 1000” олон нийтийн төвүүдийн зураг төсөл хийгдэж бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

### “Их тойруу” хотын хуучин төв

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 28/13 дугаар тогтоолоор батлагдсан “Бага тойруугийн хуучин барилгыг буулгах, оновчтой төлөвлөлтийн Техник, эдийн засгийн үндэслэл”-ээр орон зайн ашиглалтын хуучин барилгын төлөвлөлтийг үлдэх буюу хадгалагдах барилга, байгууламж, шинэчлэн сайжруулах барилга, дахин төлөвлөгдөх гэсэн үндсэн 3 шийдэлтэй байхаар төлөвлөсөн байна.

Үлдэх буюу хадгалагдах барилга, байгууламж

- 1971 оноос хойш ашиглалтад орсон, орон зайн ашиглалт сайн барилга байгууламж болон Улаанбаатар хотын түүхийн дурсгалт барилга байгууламжууд багтана. Хадгалагдах барилгыг улс, нийслэлийн тусгай хамгаалалтад авч бэхлэх, сэргээн

засварлах ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ. Цаашид улс нийслэлийн хамгаалалтад авах 52 барилга байгууламж байгаа ба тэдгээрийн 30 барилга нь 1962 оноос өмнө ашиглалтад орсон орон сууцны барилга байна.

#### Шинэчлэн сайжруулах барилга

- 1971 оноос хойш баригдсан барилга болон Улаанбаатар хотын архитектур түүх дурсгалын илэрхийлэл болсон хуучны барилга байгууламжууд багтана. Эдгээр барилгыг буулгаж шинэчлэн барилгажуулна. Төлөвлөлтийн нутаг дэвсгэрт шинэчлэн сайжруулах 101 ш барилга хамаарагдах ба үүнээс 42 барилга орон сууц, 61 олон нийт, цэцэрлэг сургуулийн барилга байгууламж байна.

#### Дахин төлөвлөгдөх

- Газар хөдлөлтөд тэсвэргүй, ашиглалтын шаардлага хангахгүй барилга болон орон сууцны хороололд зайлшгүй байх шаардлагагүй аж ахуй, агуулахын зориулалттай барилга байгууламж бүхий газар хамаарагдана. Төлөвлөлтийн нутаг дэвсгэрт 161 барилга хамаарагдаж байгаагаас 66 барилга нь орон сууцны барилга байна. Дахин барилгажуулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүрэн бололцоотой байна.

#### “Яармаг” хотын шинэ төв

“Яармаг” хотын шинэ төвийг байгуулах ажлын хүрээнд “Нисэх Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөө” боловсруулагдаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан. “Яармаг” хотын шинэ төвийн бүтээн байгуулалт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор, өндөр давхрын орон сууцны хороолол, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын цогцолбор, амины сууцны хороолол үйл ажиллагаа явагдаж байна.

Зураг 6. Яармаг хотын шинэ төвийн бүтээн байгуулалт





Эх сурвалж. [https://www.oly.mn/location-profiles/Ultimate\\_guide\\_to\\_Yarmag/](https://www.oly.mn/location-profiles/Ultimate_guide_to_Yarmag/)

## “Баянхошуу” дэд төв

“Баянхошуу” дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан. Дэд төвийн 325 га нутаг дэвсгэр дээр 40,000 хүн амтай байхаар төлөвлөсөн байна.

Зураг 7. “Баянхошуу” дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө





### Хотын дэд төв, олон нийтийн төвийн бүтээн байгуулалт

Хотын дэд төвүүдийг бий болгох ажлын хүрээнд “Баянхошуу”, “Сэлбэ” дэд төвүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан. Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн I үе шатны хүрээнд Сэлбэ, Баянхошуу дэд төвүүдийн бүтээн байгуулалтыг Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хийж байна. Дэд төв, олон нийтийн төвийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Хотын дэд төв, олон нийтийн төвийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт

№	Бүтээн байгуулалт	Баянхошуу дэд төв /162 га/	Сэлбэ дэд төв /156 га/	Дамбадаржаа дэд төв /70 га/	Дэнжийн мянга дэд төв/131.5 га/
Нийгмийн дэд бүтэц	Цэцэрлэг	150, 240 хүүхэд	150, 240 хүүхэд	150 хүүхэд	240 хүүхэд
	Эрүүл мэндийн төв	-	-	-	-
	Спорт цогцолбор	1		1	-
	Бизнес инкубатор	1	1	-	-
	Сургалтын төв			-	-
	Олон нийтийн хөгжлийн төв	1	-	1	1
Авто зам, огоон байгууламж	Цэцэрлэгт хүрээлэн	2 га	-	1.57 га	1.57 га
	Тохижилт	4.65 га	3.01 га	-	-
	Авто зам	7.42 км	6.7 км	2.8 км	3.4 км
Инженерийн дэд бүтэц	Цахилгаан хангамж	7 км	5.3 км	12 км	29 км
	Холбооны шугам			6.3 км	
	Дулаан хангамж	15 км	9.97 км	3.2 км	4.2 км
	Ус хангамж	28.83	19.78 км	5 км	8.1 км
	Ариутгах татуурга			4.6 км	5.7 км
	Үерийн хамгааллын далан	9.97 км	2.4 км	-	-
	Усан сан	1000 м3	1000 м3	-	-
	Мэдээлэл холбооны төв	1	1	-	-
	Мэдээлэл хобооны нэгдсэн үйлчилгээний төв			1	1
	Дэд станц	1	1	58 мВт дулааны станц	47 мВт дулааны станц
Цахилгааны дэд өртөө	-	-	Цахилгааны дэд өртөө	Цахилгааны дэд өртөө	

Эх сурвалж. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн явцын тайлан

Зураг 9. “Баянхошуу” дэд төвд баригдсан 240 хүүхдийн цэцэрлэг



Зураг 10. “Баянхошуу” дэд төвд баригдсан МСҮТ, бизнес инкубатор төв



Зураг 11. “Баянхошуу” дэд төвийн үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралт



Эх сурвалж. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн явцын тайлан



Зураг 12. “Сэлбэ” дэд төвд баригдсан 240 хүүхдийн цэцэрлэг



Зураг 13. “Сэлбэ” дэд төвд баригдсан МСҮТ, бизнес инкубатор төв



Зураг 14. “Сэлбэ” дэд төвд баригдсан усан сан, насос станц



Эх сурвалж. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн явцын тайлан

### “Дамбадаржаа”, “Дэнжийн 1000” олон нийтийн төв

“Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн II үе шатны хүрээнд “Дамбадаржаа”, “Дэнжийн 1000” олон нийтийн төвүүдийн барилгажилтын төсөл батлагдсан бөгөөд бүтээн байгуулалтыг Азийн хөгжлийн банк, Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр эхлүүлээд байна. Тус дэд төв, олон нийтийн төвүүдийн бүтээн байгуулалт хийгдсэнээр иргэд, олон нийтэд үзүүлэх нийгмийн болон төрийн үйлчилгээний тэгш хүртээмж нэмэгдэж, хотын хэт төвлөрөл багасах юм.

Зураг 15. “Дамбадаржаа” олон нийтийн төвийн төлөвлөлт



Төслийн хүрээнд гэр хороололд нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хүртээмж нэмэгдэж, ажлын бий болж байгаа нь сайшаалтай боловч “Баянхошуу”, “Сэлбэ” дэд төв, “Дамбадаржаа”, “Дэнжийн 1000” олон нийтийн төвүүдийн төлөвлөлтийн концепц, шийдэл нь нэгнээсээ ялгарах онцлог, давуу тал байхгүй байгаа нь иргэд, олон нийтийг татах, дэд төвүүдийн хөгжлийг хурдасгах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгөхгүй байна. Цаашид тухайн дэд төвүүдийн газар нутаг, нийгэм эдийн засгийн онцлогт тусгуурлан өөрийн гэсэн өвөрмөц, шинэлэг төлөвлөлт, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох шаардлагатай.

## 2.1 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

### ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Баянгол дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын суурьшлын бүс дотор 11.2 га талбайг Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу “Бичил” олон нийтийн төв болгон хөгжүүлэхээр техник эдийн засгийн суурь судалгааг боловсруулж 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 25 дугаар хурлын шийдвэрийн дагуу хоёрдугаар байршил дээр барилгажилтын төслийг нарийвчлан боловсруулж байна. Бичил олон нийтийн төвийг байгуулснаар тухайн гэр хорооллын суурьшлын бүсийн амьдрах орчинг өөрчлөх, ажлын байрыг нэмэгдүүлэх, нийгмийн дэд бүтцийн хүртээмж, олон нийтийн амарч зугаалах талбайг нэмэгдүүлэхэд төлөвлөлтийн үндсэн үзэл санаа оршиж байна.

Хүснэгт 2. Техник эдийн засгийн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Одоогийн байдал	Төлөвлөлт	
				Төлөвлөлтийн хүчин чадал	Нийт хүчин чадал
1	<b>Төлөвлөлтийн газар нутаг</b>	<b>Га</b>	<b>11.2</b>	-	-
Хүн ам, өрх					
1.	Хүн амын тоо	Хүн	1390	816	816
2.	Өрхийн тоо, үүнээс:	Өрх	386	219	219
3.	Суурьшлын бүсийн нягтрал	хүн/га	124	72	72
Орон сууцны хангамжийн төрөл					
4.	Нийтийн орон сууц	Өрх	82	-	82
5.	Дунд давхрын орон сууцны бүсэд	Өрх	-	137	137
Нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж					
6.	Ерөнхий боловсролын сургууль	сурагч	-	960	960
7.	Цэцэрлэг	хүүхэд	-	140	140
8.	Өрхийн эмнэлэг	үзлэг өдөр	-	100	100
9.	Биеийн тамир спортын цогцолбор	м2	-	3460	3460
10.	Бизнес инкубатор төв	м2	-	3300	3300
Нутаг дэвсгэрийн бүтэц					
1.	Орон сууцны бүс	га	-	2.5	2.5
2.	Олон нийт, ажил хэргийн бүс	га	-	4.3	4.3
3.	Тохижилт бүхий ногоон байгууламж	га	-	1	1
4.	Жижиг дунд үйлдвэрийн бүс	га	-	1.74	1.74
5.	Инженерийн дэд бүтцийн шугам сүлжээ, зам тээврийн сүлжээ	га	-	0.62	0.62
6.	Хамгаалалтын зурвас	Га	-	1.04	1.04
	Нийт	-	-	11.2	11.2
Инженерийн дэд бүтэц					
1.	Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ / Ф250-500/	км	-	2.51	2.51
2.	Шинээр хийх үерийн хамгаалалтын далан /3*2м/	км	-	0.5	0.5
3.	Дулаан хангамж /А хувилбар/	Гкал/цаг	-	9.1	9.1

4.	Дулаан хангамж /Б хувилбар/	Гкал/цаг	-	9.68	9.68
5.	Ус хангамж	м <sup>3</sup> /хоног	-	349.5	349.5
6.	Ариутгах татуурга	м <sup>3</sup> /хоног	-	399.9	399.9
7.	Цахилгаан хангамж	кВт	-	2821.6	2821.6
<b>Замын сүлжээ, байгууламж</b>					
1.	2-р зэрэглэлийн гол гудамж зам	км	-	1.03	1.03
2.	2-р зэрэглэлийн туслах зам	км	-	1.96	1.96
3.	Явган зам	км	-	3.92	3.92
4.	Унадаг дугуйн зам	км	-	3.92	3.92

Бичил олон нийтийн төвийн төлөвлөлтийн нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг төлөвлөхдөө Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-д заасан хүчин чадлаас илүү байж хамрах хүрээнд оршин сууж буй иргэдэд үйлчлэх боломжтой байдлаар тусгав. Төлөвлөлтийн хамрах хүрээнд одоо байгаа сургууль, цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа тул Бичил олон нийтийн төвд 960 хүүхдийн сургууль, 140 хүүхдийн цэцэрлэг, 100 хүн үзлэг/өдөр өрхийн эмнэлэг, 3460 м<sup>2</sup> талбайтай биеийн тамир спортын цогцолбортой байхаар төлөвлөлтөд тусгагдсан.

Шинээр төлөвлөж буй олон нийтийн төвийн байршилд 500 метр үерийн хамгаалалтын суваг төлөвлөж одоо байгаа 3, 4-р хорооллын арын үерийн хамгаалалтын суваг байгуулахаар төлөвлөлтөд тусгасан. Дулааны сүлжээ БНБД 41-02-13-д орон сууцны барилгын 1м<sup>2</sup> талбайн дулааны томсгосон үзүүлэлт, Хавсралт-3, Халуун ус хангамжийн дундаж ачааллын томсгосон үзүүлэлтийг мөрдлөгө болгон хүн амын суурьшлын бүсийн барилгуудын дулааны нийт ачаалалыг 9.1 Гкал/цаг байхаар тооцсон. Төслийн дулаан хангамжийн эх үүсвэр дулааны нийт ачааллыг шийдлийн хувьд хоёр хувилбараар тооцож хэрэглээ, хүчин чадлыг тусгасан.<sup>1</sup> Төлөвлөлтийн нийт цахилгаан ачаалалыг “Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөх ба угсрах” БД 43-102-07 болон “Орон сууцны хороолол, хотхоны 6-10 кВ-ын сүлжээ болон РП, ТП-үүд” /УБЦТС ТӨХК-ийн техникийн шаардлагын тодорхойлолт: РП ТП/-ын дагуу тооцоход 2821.6 кВт болж байна. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-06, Ариутгах татуурга ба гадна шугам сүлжээ байгууламж БНБД 40-01-14 норм дүрмийг баримтлан хот байгуулалтын батлагдсан төслүүдийг үндэслэн ус хангамжийн 349.5 м<sup>3</sup>/хоногийн хэрэглээг хангахаар шугамын нэвтрүүлэх чадвар, хөрөнгө оруулалтын тооцоог нарийвчлан боловсруулав. Бичил олон нийтийн төвийн хувьд 349,5 м<sup>3</sup>/хоног, 29,1 хон/цаг, 8,1 л/с усны хэрэглээтэй бөгөөд цагийн хамгийн их хэрэглээг тооцон φ150 мм-ийн голчтой бохир усны шугам төлөвлөн Нутаг консалтинг ХХК-ийн боловсруулсан ажлын зурагтай бохир усны шугамд холбохоор тооцов.

## 2.1.2 ХҮН АМЫН ТӨЛӨВЛӨЛТ

Баянгол дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрийн 11.2 га талбайд 193 нэгж талбарт 386 өрхийн 1390 хүн ам оршин сууж байгаа бөгөөд төлөвлөлтөөр хүн амын суурьшлын бүсийг багасгаж олон нийт, ажил хэргийн бүсийг нэмэгдүүлэхээр төлөвлөлтөд туссан. “Бичил” олон нийтийн төвд төлөвлөлтөөр 219 өрхийн 816 хүн амтай байхаар төлөвлөлтийг боловсрууллаа.

<sup>1</sup> Төлөвлөлтийн тайлбар бичгийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл бүлгээс дэлгэрэнгүй тооцоо, хүчин чадлын тайлбарыг үзнэ үү.

## ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Хүснэгт 3. Орон сууцны төлөвлөлт

Код	Төрөл	давхар	барилгын тоо	Суурь	Барилгын талбай	Төлөвлөлтийн Нийт м2	Өрх
Төлөвлөлтийн орон сууц							
1	Орон сууц	5	5	380	1,900	9,500	125
2	Орон сууц	3	1	250	750	750	12
Одоогийн байдал							
3	Нийтийн байр-1	2	1	136	136	-	20
4	Нийтийн байр-2	3	1	250	250	-	22
5	Нийтийн байр-3	2	1	194	194	-	20
6	Нийтийн байр-4	2	1	250	250	-	20
	БҮГД	-	-	-	-	10250	219

“Бичил” олон нийтийн төвийн одоогийн байдлын судалгаагаар одоо ашиглаж байгаа нийтийн байр, үйлчилгээний талбайгаа өөрчлөх сонирхолгүй, хэвээр үлдээх хүсэлтэй иргэн аж ахуйн нэгж байгууллагын орон сууцыг үлдээж төлөвлөлтөөр 3-5 давхрын 6 орон сууцыг төлөвлөлтөд тусгав. Дунд давхрын орон сууцыг архитектур орон зайн хувьд барилга хоорондын сүүдэрлэлтийг тооцож ашиглалт сайтай, Монгол Үндэсний уламжлалт гэр хэлбэрийн дизайнтай, иргэдийн амьдрах орчин нөхцөл, тав тухтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайг норм, стандартын дагуу төлөвлөлтөд тусгасан.

## ОЛОН НИЙТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАНГАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Хүснэгт 4. Олон нийт, үйлчилгээний хангамжийн төлөвлөлт

Код	Үзүүлэлт	давхар	Суурь	Барилгын талбай	Нийт м2	Хэмжих нэгж	Хүчин чадал
1	Спорт цогцолбор	2	1,730	3,460	3,460	Шалны талбай м <sup>2</sup>	3,460
2	Эрүүл мэндийн төв	2	325	650	650	Хүн үзлэг/өдөр	100
3	Цэцэрлэг	2	576	1,152	1,152	Хүүхэд	140
4	Сургууль	2	1,583	3,166	3,166	Сурагч	960
5	Бизнес инкубатор төв /номын сан/	3	1,100	3,300	3,300	Номын сангийн талбай м <sup>2</sup>	1,100

“Бичил” олон нийтийн төвийн 11.2 га нутаг дэвсгэрт байгуулах олон нийтийн барилга байгууламжийн хүчин чадлыг төлөвлөхдөө хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30.01.04-д заасан хүчин чадлаас илүү байхаар тооцож Баянгол дүүргийн 9, 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт оршин сууж буй иргэдэд үйлчлэх хүчин чадалтай байхаар тооцсон.

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТООЦОО**

Хүснэгт 5. Ажиллах хүчний тооцоо

Код	Агуулга	давхар	барилгын тоо	Суурь	Барилгын талбай	Нийт м2	Ажлын байр
<b>Төлөвлөлтөөр</b>							
2	Худалдаа үйлчилгээ	1	1	1,500	1,500	1,500	46
3	Спорт цогцолбор	2	1	1,730	3,460	3,460	30
4	Эрүүл мэндийн төв	2	1	325	650	650	50
5	Үйлчилгээ	2	1	360	720	720	22
6	Худалдаа үйлчилгээ	3	1	1,643	4,929	4,929	152
7	Цэцэрлэг	2	1	576	1,152	1,152	60
8	Сургууль	2	1	1,583	3,166	3,166	100
10	Бизнес инкубатор төв	3	1	1,100	3,300	3,300	76
11	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-1	2	1	810	1,620	1,620	23
12	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-2	3	1	486	1,458	1,458	20
13	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-3	2	1	700	1,400	1,400	20
14	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-4	2	1	324	648	648	9
15	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-5	2	1	432	864	864	12
16	Инженерийн дэд бүтэц	-	-	-	-	-	10
	Нийт	-	-	-	-	-	620
<b>Одоо байгаа барилга</b>							
17	Үйлчилгээ	2	1	156	312	312	6
18	Гарааш	1	1	78	78	78	1
19	Авто засвар	1	1	445	445	445	6
20	Дэлгүүр	1	1	134	134	134	3
21	Авто засвар-1	1	1	354	354	354	6
22	Авто засвар-2	1	1	343	343	343	5
23	Авто засвар-3	2	1	300	600	600	5
24	Авто засвар-4	2	1	184	368	368	3
	Нийт						35
	<b>БҮГД</b>						<b>655</b>

“Бичил” олон нийтийн төвийн 11.2 га нутаг дэвсгэрт одоо үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн ажлын байрыг хадгалах, Баянгол гол дүүргийн нутаг дэвсгэрт хотын зам дагуу үйл ажиллагаа явуулдаг авто засварын газрыг төрөлжүүлэн хөгжүүлэхээр төлөвлөлтөд туссан. Тухайн төлөвлөлтийн хязгаарт одоо 35 ажлын байр байдаг бол төлөвлөлтөөр 620 ажлын байрыг нэмэгдүүлж нийтдээ 655 байнгын ажлын байрыг бий болгохоор төлөвлөлтөд тусгагдсан.

## 2.1 ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

### ИНЖЕНЕРИЙН БЭЛТГЭЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 9,10 дугаар хорооны нутаг дэвсгэр 11,2 га талбайд Бичил олон нийтийн төвийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах талбай оршино. Ус зүйн хувьд төлөвлөлтийн талбай нь хойд талаасаа 2 ширхэг сайр байгалийн гуу жалгаар үерийн ус орж ирнэ.

Зураг 16. Ус хураах талбайн зураглал



Төлөвлөлтийн хязгаарт орж буй талбайн газрын гадаргуугийн байдлыг байр зүйн зураглал дээр судлаж үзэхэд далайн төвшнөөс дээш хойноосоо урагшаа үнэмлэхүй өндөр нь 1383.56-1365.09 метрт өргөгдсөн, өндөржилтийн зөрүү 18,47 метр, талбайн хойд тал зүүнээсээ баруун тийш 1383.56-1381.46 метрт өргөгдсөн, өндөржилтийн зөрүү 2,1 метр, талбайн урд хэсэг баруунаасаа зүүн тийш 1365.09-1364.67 метрт өргөгдсөн, өндөржилтийн зөрүү 2,1 метр байна.

#### Инженер геологийн судалгаа

Судалгааны талбай нь инженер-геологийн дунд зэргийн төвөгтэй нөхцөлд оршино. Геоморфологийн нөхцөлийн татмын дээрх хэсэгт, шавранцараар чигжидсэн хайрган хөрс улирлын хөлдөлтийн бүсэд сулавтар овойлт үүсгэнэ. Асгамал хөрс талбайн хэмжээнд гүехэн тархсан. Ул хөрсний усны өлгөмөл байдлаар тархдаг. Судалгааны талбайд өмнө хийсэн хээрийн судалгаа болон нэмэлтээр хийсэн судалгаагаар ул хөрсний физик механик шинж чанарыг ялгаж инженер-геологийн элемент ялган тооцоолсон.

Хүснэгт 6. Мэдээлэл холбооны сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Механик шинж чанарын үзүүлэлтүүд	Индекс	Хэмжих нэгж	Хөрсний нэр		
				Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс /ИГЭ-1/	Хайрга агуулсан шавар ул хөрс /ИГЭ-2/	Хайргархаг шавранцар ул хөрс /ИГЭ-3/
1.	Зууралдлын хүч	C <sub>н</sub>	кПа	25	81	47
			кгс/см <sup>2</sup>	C <sub>н</sub> =C <sub>н1</sub> =16кПа буюу 0.016кгс/см <sup>2</sup>	C <sub>1</sub> =54 кПа буюу 0.54 кгс/см <sup>2</sup>	C <sub>1</sub> =31 кПа буюу 0.31кгс/см <sup>2</sup>
2.	Дотоод үрэлтийн өнцөг	φ <sub>н</sub>	град	31°	21°	25°
				φ <sub>н</sub> =φ <sub>н1</sub> =27°	φ <sub>н</sub> =φ <sub>н1</sub> =18°	φ <sub>н</sub> =φ <sub>н1</sub> =25° φ <sub>1</sub> =22°
3.	Хэв гажилтын модуль	E	МПа	38	31	26
4.	Барагцаалсан тооцооны эсэргүүцэл	R <sub>0</sub>	кПа	450	400	300
				R <sub>0</sub> = 450кПа буюу 4.5 кгс/см <sup>2</sup>	R <sub>0</sub> = 400кПа буюу 4.0 кгс/см <sup>2</sup>	R <sub>0</sub> = 300кПа буюу 3.0 кгс/см <sup>2</sup>

Гидрогеологийн нөхцөлийн хувьд судалгааны талбайн хэсэгт өлгөмөл ус илэрдэг хэсэг бөгөөд өмнөх судалгаагаар нотлогдож байна. Судалгааны талбайн урд хэсэг 3.5-12.5 метрт илэрч тогтсон. 2021 оны 10-р сарын 25-ны өдрийн 8 цооног өрөмдөхөд хөрсний ус илрээгүй байна. Талбайн хэмжээнд талбайн угаагдал нь орох хур тунадасны хэмжээнээс шалтгаалж харилцан адилгүй эрчимтэй явагдах бөгөөд гадаргуугийн намссан хэсэгт цугларч үерийн ус зайлуулах сувгаар зайлуулагдана. Талбайн угаагдал судалгаа хийгдсэн талбайн хойноос урагш чиглэн явагдана.

- Улирлын хөлдөлтийн норматив гүн: Шавранцараар чигжигдсэн хайрган хөрс-3.80м
- Ул хөрсний газар шорооны ажлын зэрэг: Шавранцараар чигжигдсэн хайрган хөрс-IV
- Судалгааны талбай нь газар хөдлөлтийн 7 баллын бүсэд оршино.
- Хөрсний оргил хурдатгал 110-142 см/с2


Энэ дүгнэлт нь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шатанд боловсруулагдсан учир шинээр томоохон барилга байгууламж барьж байгуулахад ажлын зургийн шатанд инженер-геологийн нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй

Төлөвлөлтийн талбайд хийгдсэн “Лэнд тест” ХХК-ийн инженер геологийн судалгаа, одоо байгаа үерийн ус орж ирэх гуу жалга, авто замын төлөвлөлттэй уялдуулан дараах усны барилга байгууламжуудыг барьж байгуулна. Үүнд:

- Үерийн хамгаалалтын байгууламж
- Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ



Зураг 17. Ус хураах талбайн




- Төлөвлөж буй ил үерийн хамгаалалтын суваг
- Одоо байгаа үерийн хамгаалалтын суваг
- Төлөвлөж буй борооны ус зайлуулах шугам сүлжээ
- Байгалийн гуу жалга

### Үерийн хамгаалалтын сувгийн төлөвлөлт

Шинээр төлөвлөж буй олон нийтийн төвийн байршилд 500 метр үерийн хамгаалалтын суваг төлөвлөж одоо байгаа 3,4-р хорооллын арын үерийн хамгаалалтын сувагт холбоно. Үүнд: Уулаас буух үерийн усыг ус хүлээн авах байгууламжаар тосон авч угсармал төмөр бетон трапец хэлбэртэй үерийн хамгаалалтын 500 метр сувгаар зайлуулна.

Угсармал төмөр бетон трапец хэлбэртэй ил үерийн сувгийн хөндлөн огтлол

Зураг 18. Ус хураах



Хүснэгт 7. Мэдээлэл холбооны сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо


д/д	Нэр	Сувгийн урт	Хийц, диаметр	Байгууламж	Холболтын цэг
1	Шинээр хийх ил үерийн хамгаалалтын суваг	500 м	Төмөр бетон трапец хэлбэртэй	Ус хүлээн авах байгууламж-1, Ус гаргуур-2	3,4-р хорооллын арын суваг

Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний төлөвлөлт

Шинээр төлөвлөж байгаа авто замын төлөвлөлт, ус цуглуулах талбайг тооцон 2500 метр борооны ус зайлуулах шугам сүлжээ хийж үерийн хамгаалалтын суваг болон замын доорх ус гаргуурт холбохоор төлөвлөв. Үүнд: Шинээр хийгдэх борооны усны шугам сүлжээ 2500 метр байна. Борооны ус цуглуулах шүүрт болон үзлэгийн худаг 50 ширхэг хийхээр төлөвлөв.




Зураг 12. Борооны ус зайлуулах шугам сүлжээний үзлэгийн худгийн хөндлөн огтлол






Хүснэгт 8. Мэдээлэл холбооны сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

д/д	Хамрах хүрээ	Нийт урт, м	Хийц, диаметр	Үзлэгийн худгийн тоо	Холболтын цэг
1	9,10 хороо	2500	Ф250-500 бетон лотки	50 ширхэг	3,4-р хорооллын арын суваг

Зураг 19. Ус хураах



-  Төлөвлөж буй ил үерийн хамгаалалтын суваг
-  Одоо байгаа үерийн хамгаалалтын суваг
-  Төлөвлөж буй борооны ус зайлуулах шугам сүлжээ

### Хөрсний ус зайлуулах шугам сүлжээний төлөвлөлт

Төлөвлөлтийн талбайн хамрах хүрээнд 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хийгдсэн инженер геологийн судалгааны 2.5-6.0 метрийн гүнтэй 8 ширхэг цооногийн мэдээллээр хөрсний ус илрээгүй байна. Иймээс хөрсний усны шүүрүүлийн байгууламж болон зайлуулах шугам сүлжээ хийх шаардлагагүй.

### Зөвлөмж

Цаашид ажлын зураг төслийн шатанд инженер геологи, гидрологи ус зүйн тооцоо судалгаа хийж үерийн хамгаалалтын суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний өргөн, диаметр техникийн шийдлийг гаргах шаардлагатай. Өндөржилтийн зөрүү 18,47 метр байгаа тул газар шорооны ухлагын ажил ихтэй, шугам сүлжээ хэвгий ихтэй хийгдэх тул ажлын зураг төслийн шатанд тооцоо судалгааг нарийчлан хийх шаардлагатай.

Инженерийн бэлтгэл арга хэмжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Хүснэгт 9. Мэдээлэл холбооны сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хөрөнгө оруулалт /сая.төг/		
					Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
1	Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ	Ф250-Ф300мм	км	2.51	1,248.47	49.94	1,298.41
2	Бетон хучилттай үерийн хамгаалалтын далан суваг	3Х2 м	км	0.5	877.50	35.10	912.60
3	ДҮН				<b>2,125.97</b>	<b>85.04</b>	<b>2,211.01</b>

**Тайлбар:**

Барилга хот байгуулалтын сайдын тушаал 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 203 дугаар тушаалаар баталсан нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм “БД 81-106-16”-ийг баримтлан тооцсон.

Үнийн өсөлтийн индексийг 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 74 дугаартай тушаалаар шинэчлэн баталсанг үндэслэл болгов.

## ДУЛААН ХАНГАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Тус байршил нь уур амьсгалын II бүсэд хамаарах бөгөөд галлагааны хугацаа 9-р сарын 15- наас эхлэн 5-р сарын 12 хүртэл 239 хоног үргэлжилнэ. Халаалтын улирлын тооцооны дундаж температур  $-11.4^{\circ}\text{C}$ , гадна агаарын тооцоот температурыг БНБД 23-01-09 Барилгад хэрэглэгдэх уур амьсгал, геофизикийн үзүүлэлтийн дагуу  $t_{1\text{хон}}=-35.3^{\circ}\text{C}$ ,  $t_{3\text{хон}}=-34.2^{\circ}\text{C}$ ,  $t_{5\text{хон}}=-29.9^{\circ}\text{C}$ , салхивчийн  $t$  хон =  $-25.8^{\circ}\text{C}$ -ээр тус тус тооцов. Хот байгуулалтын архитектор, эдийн засагчдын тооцоолсон хүн амын өсөлт, барилга байгууламжийн талбай зэргийг үндэслэн, БНБД 41-02-13-ын Хавсралт-3, Орон сууцны барилгын  $1\text{м}^2$  талбайн дулааны томсгосон үзүүлэлт, Хавсралт-3, Халуун ус хангамжийн дундаж ачааллын томсгосон үзүүлэлтийг мөрдлөгө болгон дулааны ачаалалыг тооцоолсон. Төлөвлөж буй суурьшлын бүсийн барилгуудын дулааны нийт ачаалал **9.1** Гкал/цаг. Үүнд:

- Халаалтын системийн ачаалал **3.88** Гкал/цаг,
- Агаар сэлгэлтийн нийт ачаалал **1.17** Гкал/цаг,
- Хэрэгцээний халуун усны ачаалал **2.53** Гкал/цаг, тус тус байна.

Төлөвлөлтийн байршилд шинээр баригдах барилгууд нь эрчим хүчний А, В үнэлгээнд багтсан эрчим хүчний хэмнэлттэй барилгууд байна. Эрчим хүч хэмнэлтийн В, А, А+, А++ ангилалыг хангахын тулд дараах эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээнүүдийг заавал тусгасан байх ёстой. Үүнд:

- Хэрэгцээний халуун усны системийн эргэлтийн эрчим хүчний зарцуулалтыг бууруулах бие даасан дулааны зангилаа ба халуун, хүйтэн усны удирдлагын болон эрчим хүчний хэрэгцээний автомат системтэй байх;
- Барилгын өрөөнүүд хөдөлгөөн ба гэрэл мэдрэгч бүхий эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлгийн систем ашиглах;
- Цахилгаан шат, насос ба агаар сэлгэлтийн тоног төхөөрөмжийн хөдөлгүүрт реактив чадлын компенсацийн төхөөрөмж ашиглах.
- А буюу өндөр эрчим хүчний хэмнэлттэй олон нийтийн барилгын зохиомол өдөөлттэй агаар сэлгэлтийн систем нь дулаан эргүүлэн ашиглагчтай байна.
- А+ буюу бага эрчим хүчний барилгын хувьд зохиомол өдөөлттэй агаар сэлгэлтийн систем нь дулаан эргүүлэн ашиглагчтай, дулааны гүүрний эсрэг арга хэмжээ авч баталгаажуулан үр дүнг үнэлсэн байна.
- А++ буюу Пассив барилгын хувьд пассив сууцны институтын (The Passive House Institute) боловсруулсан энэ төрлийн барилгад тавигдах шаардлагуудаас барилгын халаалтын жилийн хувийн эрчим хүчний хэрэгцээ  $15\text{кВт}\cdot\text{ц}/(\text{м}^2 \cdot \text{жил})$ -аас бага байх, халаалтын ачаалал  $10\text{Вт}/\text{м}^2$  -аас бага байх 2 шаардлагын бусдыг нь хангасан байна.

### Дулаан ачааллын тооцоо

Хүснэгт 10. Мэдээлэл холбооны сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Код	Зориулалт	давхар	Барилгын тоо	Барилгын талбай м2	Өрх	Хүн ам	Ажлын байр	Дулааны ачаалал Гкал/цаг				
								Халаалт	ХХУ	Салхивч	Нийт	
<b>Төлөвлөлт</b>												
1	Орон сууц	5	5	9,500	125	475	-	2.72	2.09	0.82	5.63	
2	Худалдаа үйлчилгээ	1	1	1,500		0	46	0.07	0.02	0.02	0.11	
3	Спорт цогцолбор	2	1	3,460		0	30	0.15	0.01	0.05	0.21	
4	Эрүүл мэндийн төв	2	1	650		0	50	0.03	0.03	0.01	0.07	
5	Худалдаа үйлчилгээ	3	1	4929		0	64	0.22	0.02	0.06	0.30	
6	Цэцэрлэг	2	1	1,152			140	0.05	0.08	0.02	0.15	
7	Сургууль	2	1	3,166		960	100	0.14	0.06	0.04	0.24	
8	Орон сууц	3	1	500	12	46	-	0.02	0.04	0.01	0.07	
9	Бизнес инкубатор төв	3	1	1,595		0	76	0.07	0.02	0.02	0.11	
10	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-1	2	1	1,620			36	0.07	0.01	0.02	0.10	
11	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-2	3	1	1,458		0		0.06	-	0.02	0.08	
12	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-3	2	1	1,400		0	34	0.06	0.01	0.02	0.09	
13	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-4	2	1	648		0	25	0.03	0.007	0.01	0.04	
14	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-5	2	1	432		0		0.02	-	0.01	0.02	
15	Худалдаа үйлчилгээ	2	1	842		0	18	0.04	0.01	0.01	0.05	
16	Худалдаа үйлчилгээ	2	1	300		0	18	0.01	0.01	0.00	0.02	
	<b>Нийт</b>					<b>137.0</b>	<b>1,481.0</b>	<b>647.0</b>	<b>3.76</b>	<b>2.41</b>	<b>1.13</b>	<b>7.30</b>

Одоо байгаа барилгын хэрэглээ									-	-	-	-
16	Нийтийн байр-1	2	1	136	20	72		0.01	0.03	0.00	0.03	
17	Нийтийн байр-2	3	1	250	22	79		0.01	0.03	0.00	0.04	
18	Үйлчилгээ	2	1	156			6	0.01	0.002	0.00	0.01	
19	Гарааш	1	1	78			1	0.00	0.000	0.00	0.00	
20	Нийтийн байр-3	2	1	194	20	72		0.01	0.03	0.00	0.04	
21	Нийтийн байр-4	2	1	250	20	72		0.01	0.03	0.00	0.04	
22	Авто засвар	1	1	445			6	0.02	0.002	0.01	0.03	
23	Дэлгүүр	1	1	134			3	0.01	0.001	0.00	0.01	
24	Авто засвар-1	1	1	354			6	0.02	0.002	0.00	0.02	
25	Авто засвар	1	1	343			6	0.02	0.002	0.00	0.02	
26	Авто засвар	1	1	300			6	0.01	0.002	0.00	0.02	
27	Авто засвар	1	1	184			6	0.01	0.002	0.00	0.01	
	Одоо байгаа барилгын дулааны хэрэглээ							0.12	0.12	0.04	0.28	
	Нийт дулааны хэрэглээ							3.88	2.53	1.17	7.58	
	нөөц	<b>20%</b>									<b>1.52</b>	
	<b>БҮГД</b>										<b>9.10</b>	

Төлөвлөлтийн бүсийн барилга байгууламжуудын халаалтын системд 3.88 Гкал/цаг, хэрэгцээний халуун усны системд 2.53 Гкал/цаг, салхивчийн системд 1.17 Гкал/цаг, **НИЙТ 7,58Гкал/цаг**-ийн дулааны эрчим хүчний хэрэглээ шаардлагатай. Төлөвлөлтийн бүс нь төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдох боломжгүй, төвлөрсөн дулааны эх үүсвэр, дулааны шугам сүлжээнээс хэт алслагдсан байршилд байрладаг, геодезийн өндрийн 1265-1282 метрийн түвшинд байршиж байна. Иймээс тус бүсэд дулааны хэсэгчилсэн хий хангамжийн эх үүсвэр төлөвлөсөн. Төлөвлөж буй эх үүсвэрийн хүчин чадлыг шаардлагатай ачааллыг 20 хувиар нэмэгдүүлэн **9,1 Гкал/цаг** байхаар төлөвлөв. Төлөвлөлтийн бүсэд байрлах нийслэлийг цагдаагийн эрүүлжүүлэн саатуулах газрын DZL 0.7-0.7 хүчин чадалтй 1500 м3 эзэлхүүн бүхий 3 объект халаадаг 2 ширхэг зуухны барилгыг буулган дэвшилтэт технологи бүхий хий хангамжийн эх үүсвэр төлөвлөсөн. 2x25м3 хий нөөцлөх сав далд угсарна.

Зураг 20. Ус хураах



Төлөвлөж буй эх үүсвэрээс 2 ус дулаан хуваарилах төв барьж хангахаар тооцов. Дулааны эх үүсвэрээс ДХТ хүртэл дулааны сувагт цэвэр усны шугам хамт угсрахаар төлөвлөлтөд тусгасан.





Хүснэгт 11. Төлөвлөж буй олон нийтийн төвийн дулаан хуваарилах төв-1-ээс тэжээгдэх хэрэглэгчдийн хангамжийн ачаалал

Код	Зориулалт	давхар	барилгын тоо	Барилгын талбай м2	Өрх	Хүн ам	Дулааны ачаалал Гкал/цаг				
							Халаалт	ХХУ	Салхивч	Нийт	
<b>ЦТП-1</b>											
<b>ТӨЛӨВЛӨГДСӨН БАРИЛГУУД</b>											
1	Орон сууц	5	2	9,500	125	475	1.09	0.84	0.33	2.25	
2	Худалдаа үйлчилгээ	1	1	1,500		0	0.07	0.02	0.02	0.11	
3	Спорт цогцолбор	2	1	3,460		0	0.15	0.01	0.05	0.21	
4	Эрүүл мэндийн төв	2	1	650		0	0.03	0.03	0.01	0.07	
5	Худалдаа үйлчилгээ	3	1	4929		0	0.22	0.02	0.06	0.30	
6	Цэцэрлэг	2	1	1,152			0.05	0.08	0.02	0.15	
15	Худалдаа үйлчилгээ	2	1	842		0	0.04	0.01	0.01	0.05	
16	Худалдаа үйлчилгээ	2	1	300		0	0.01	0.01	0.00	0.02	
	<b>Нийт</b>					<b>125.0</b>	<b>475.0</b>	<b>1.65</b>	<b>1.01</b>	<b>0.50</b>	<b>3.16</b>

ОДОО БАЙГАА БАРИЛГУУД							-	-	-	-
25	Нийтийн байр-1	2	1	136	20	72	0.01	0.03	0.00	0.03
26	Нийтийн байр-2	3	1	250	22	79	0.01	0.03	0.00	0.04
27	Үйлчилгээ	2	1	156			0.01	0.002	0.00	0.01
28	Гарааш	1	1	78			0.00	0,00	0.00	0.00
	Одоо байгаа барилгын дулааны хэрэглээ						0.03	0.06	0.01	0.09
	<b>НИЙТ /ЦТП-1/</b>						<b>1.68</b>	<b>1.07</b>	<b>0.50</b>	<b>3.25</b>
	<b>нөөц</b>	<b>20%</b>								<b>0.65</b>
	<b>НИЙТ ХЭРЭГЛЭЭ</b>						<b>-</b>			<b>3.90</b>

Дулаан хуваарилах төв-1-ээс 125 өрхийн 2233 м<sup>2</sup> талбай бүхий 2-5 давхар 9 блок орон сууц, олон нийтийн барилга байгууламжуудын 3.16Гкал/цаг-ийн дулааны хэрэглээ тэжээгдэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулагдсан. Төлөвлөлтийн бүсэд одоо байгаа 4 блок барилгын 620м<sup>2</sup> талбайд 0.09Гкал/цаг-ийн дулааны хэрэглээ шаардлагатай байна.

Хүснэгт 12. Төлөвлөж буй олон нийтийн төвийн дулаан хуваарилах төв-2-с тэжээгдэх хэрэглэгчдийн хангамжийн ачаалал

Код	Зориулалт	давхар	барилгын тоо	Барилгын талбай м <sup>2</sup>	Өрх	Хүн ам	Дулааны ачаалал Гкал/цаг				
							Халаалт	ХХУ	Салхивч	Нийт	
<b>ЦТП-2</b>											
<b>ТӨЛӨВЛӨГДСӨН БАРИЛГУУД</b>											
1	Орон сууц	5	3	9,500	125	475	1.63	1.25	0.49	3.38	
7	Сургууль	2	1	3,166		960	0.14	0.06	0.04	0.24	
8	Орон сууц	3	1	500	12	46	0.02	0.04	0.01	0.07	
9	Бизнес инкубатор төв	3	1	1,595		0	0.07	0.02	0.02	0.11	
10	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-1	2	1	1,620		0	0.07	0.01	0.02	0.10	
11	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-2	3	1	1,458		0	0.06	-	0.02	0.08	
12	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-3	2	1	1,400		0	0.06	0.01	0.02	0.09	
13	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-4	2	1	648		0	0.03	0.007	0.01	0.04	
14	Авто засвар үйлчилгээний төвлөрсөн төв-5	2	1	432		0	0.02	-	0.01	0.02	
	<b>Нийт</b>					<b>137</b>	<b>1,481</b>	<b>2.11</b>	<b>1.40</b>	<b>0.63</b>	<b>4.14</b>
<b>ОДОО БАЙГАА БАРИЛГУУД</b>											

30	Нийтийн байр-4	2	1	250	20	72	0.01	0.03	0.00	0.04
29	Нийтийн байр-3	2	1	194	20	72	0.01	0.03	0.00	0.04
31	Авто засвар	1	1	445			0.02	0.002	0.01	0.03
32	Дэлгүүр	1	1	134			0.01	0.001	0.00	0.01
33	Авто засвар-1	1	1	354			0.02	0.002	0.00	0.02
34	Авто засвар	1	1	343			0.02	0.002	0.00	0.02
35	Авто засвар	1	1	300			0.01	0.002	0.00	0.02
36	Авто засвар	1	1	184			0.01	0.002	0.00	0.01
	Одоо байгаа барилгын дулааны хэрэглээ						<b>0.06</b>	<b>0.01</b>	<b>0.02</b>	<b>0.19</b>
	<b>НИЙТ /ЦТП-2/</b>						<b>2.17</b>	<b>1.41</b>	<b>0.65</b>	<b>4.33</b>
	<b>нөөц</b>	<b>20%</b>								<b>0.87</b>
	<b>НИЙТ ХЭРЭГЛЭЭ</b>						<b>-</b>			<b>5.20</b>

Дулаан хуваарилах төв-2-оос 137 өрхийн 20319 м2 талбай бүхий 2-5 давхар 11 блок орон сууц, олон нийтийн барилга байгууламжуудын 4.14Гкал/цаг-ийн дулааны хэрэглээ тэжээгдэхээр төлөвлөлтийн шийдэл боловсруулагдсан. Төлөвлөлтийн бүсэд одоо байгаа 8 блок барилгын 2204м2 талбайд 0.19Гкал/цаг-ийн дулааны хэрэглээ шаардлагатай байна.

#### Төлөвлөж буй дулааны шугамын 1 дүгээр хэлхээний гидравлик тооцоо

Төлөвлөж буй дулааны эх үүсвэрээс дулаан хуваарилах төв 1,2 хүртэл 2ф250/219/189мм-ийн хүчин чадалтай 325 хос км дулааны шугам төлөвлөгдсөн. Дулааны эх үүсвэрээс дулаан хуваарлах төв 1, 2 хүртэл 2ф250мм-ийн хүчин чадалтай 118хос.км, 2ф219мм-ийн хүчин чадалтай 172 хос.км, 2ф189мм-ийн голчтой 36 хос.км дулааны шугам нийт 1 дүгээр хэлхээний 326 хос.км дулааны шугам угсрагдана.

Хүснэгт 13. Төлөвлөж буй дулааны шугамын 1 дүгээр хэлхээний гидравлик тооцоо

Онцлох цэгүүдийн дугаар		Дулааны хэрэглээ	Шугамын мэдээлэл, тооцооны дүн										
j	i		Q ккал/ц	G <sub>0</sub> (кг/с)	a <sub>0</sub>	L (м)	L <sub>э</sub> (м)	d <sub>0</sub> (м)	d <sub>ст</sub> (м)	R <sup>ст</sup> (Па/м)	H (м)	W <sub>0</sub> (м/р)	dH (м)
	I хэлхээ												
1	Дулааны эх үүсвэрээс ДХ1 хүртэл	9,096,608.7	56.15	0.225	118.0	26.5	0.23	<b>0.250</b>	62.3	<b>0.9</b>	1.2	0.9	
2	ДХ1- ЦТП-1 хүртэл	3,898,195.9	16.66	0.122	36.0	4.4	0.14	<b>0.189</b>	23.8	<b>0.1</b>	0.6	0.1	
3	ДХ1- ЦТП-2 хүртэл	5,198,412.8	22.22	0.141	172.0	24.3	0.16	<b>0.219</b>	19.5	<b>0.4</b>	0.6	0.4	
	<b>ДҮН</b>				<b>326.0</b>								

Дулаан хуваарилах төв-1-ээс хэрэглэгч хүртэл II дугаар хэлхээний ф250/219/108/89/76/57мм-ийн голчтой 428 хос.метр дулааны шугам төлөвлөгдсөн.

Онцлох цэгүүдийн дугаар		Дулааны хэрэглээ	Шугамын мэдээлэл, тооцооны дүн										
j	i		Q ккал/ц	G <sub>0</sub> (кг/с)	a <sub>0</sub>	L (м)	L <sub>э</sub> (м)	d <sub>0</sub> (м)	d <sub>ст</sub> (м)	R <sup>ст</sup> (Па/м)	H (м)	W <sub>0</sub> (м/р)	dH (м)
	II хэлхээ												
	<b>Дулаан хангамж /Дулааны эх үүсвэрээс ЦТП-1 хүртэл/</b>												
2	ОЦ1-ээс ЦТП-1 хүртэл	3,898,195.9	36.09	0.180	6.0	1.1	0.19	<b>0.250</b>	25.7	<b>0.0</b>	0.8	0.0	
1	ОЦ-1-ээс ОЦ-2 хүртэл	2,782,496.5	25.76	0.152	20.0	3.0	0.17	<b>0.250</b>	13.1	<b>0.0</b>	0.5	0.0	
2	ОЦ-2-оос ОЦ-3 хүртэл	2,782,496.5	25.76	0.152	9.0	1.4	0.17	<b>0.200</b>	42.3	<b>0.0</b>	0.8	0.0	
3	ОЦ-3-аас ОЦ-4 хүртэл	2,572,250.3	23.82	0.146	32.0	4.7	0.16	<b>0.189</b>	48.7	<b>0.2</b>	0.9	0.2	
4	ОЦ-4-өөс ОЦ-5 хүртэл	2,505,899.7	23.20	0.145	35.0	5.1	0.16	<b>0.189</b>	46.2	<b>0.2</b>	0.8	0.2	
5	ОЦ-5-оос 1 барилга хүртэл	2,358,160.2	21.83	0.140	40.0	5.6	0.16	<b>0.189</b>	40.9	<b>0.2</b>	0.8	0.2	
6	ОЦ-5-оос 6 барилга хүртэл	147,739.4	1.37	0.035	48.0	1.7	0.05	<b>0.076</b>	19.2	<b>0.1</b>	0.3	0.1	
7	ОЦ-1-ээс ОЦ-6 хүртэл	469,303.2	4.35	0.063	50.0	3.1	0.09	<b>0.108</b>	30.6	<b>0.2</b>	0.5	0.2	
8	ОЦ-6-аас ОЦ-7 хүртэл	169,824.5	1.57	0.038	47.0	1.8	0.06	<b>0.076</b>	25.3	<b>0.1</b>	0.4	0.1	
9	ОЦ-6-аас 5 барилга хүртэл	299,478.7	2.77	0.050	11.0	0.5	0.07	<b>0.089</b>	34.4	<b>0.0</b>	0.5	0.0	
10	ОЦ-7-оос ОЦ-8 хүртэл	58,757.2	0.54	0.022	62.0	1.4	0.04	<b>0.057</b>	13.7	<b>0.1</b>	0.2	0.1	
11	ОЦ-7-оос 15 барилга хүртэл	53,231.7	0.49	0.021	68.0	1.4	0.04	<b>0.057</b>	11.3	<b>0.1</b>	0.2	0.1	
	<b>Дүн</b>				<b>428.0</b>								

Дулаан хуваарилах төв-2-оос хэрэглэгч хүртэл II дугаар хэлхээний ф250/219/108/89/76/57мм-ийн голчтой **662 хос.метр, нийт 1 416 хос.метр** дулааны шугам төлөвлөгдсөн.

Онцлох цэгүүдийн дугаар		Дулааны хэрэглээ	Шугамын мэдээлэл, тооцооны дүн									
j	i	Q ккал/ц	G <sub>0</sub> (кг/с)	a <sub>0</sub>	L (м)	L <sub>э</sub> (м)	d <sub>0</sub> (м)	d <sub>ст</sub> (м)	R <sub>ст</sub> (Па/м)	H (м)	W <sub>0</sub> (м/ñ)	dH (м)
	II хэлхээ											
<b>Дулаан хангамж /Дулааны эх үүсвэрээс ЦТП-2 хүртэл/</b>												
1	ЦТП-2-оос ОЦ-10 хүртэл	5,198,412.8	48.13	0.208	8.0	1.7	0.21	<b>0.250</b>	45.8	<b>0.0</b>	1.0	0.0
2	ОЦ-10-аас ОЦ-9 хүртэл	3,491,871.6	32.33	0.171	58.0	9.9	0.18	<b>0.219</b>	41.4	<b>0.3</b>	0.9	0.3
3	ОЦ-9-өөс 1 барилга хүртэл	3,378,743.4	31.28	0.168	95.0	15.9	0.18	<b>0.189</b>	84.0	<b>1.0</b>	1.1	1.0
4	ОЦ-9-өөс 9 барилга хүртэл	113,128.2	1.05	0.031	25.0	0.8	0.05	<b>0.076</b>	11.2	<b>0.0</b>	0.2	0.0
5	ОЦ-10-аас ОЦ-11 хүртэл	127,317.1	1.18	0.033	11.0	0.4	0.05	<b>0.076</b>	14.2	<b>0.0</b>	0.3	0.0
6	ОЦ-11-ээс ОЦ-11* хүртэл	221,993.2	2.06	0.043	18.0	0.8	0.06	<b>0.076</b>	43.3	<b>0.1</b>	0.5	0.1
7	ОЦ-11*-ээс ОЦ-12 хүртэл	119,174.6	1.10	0.032	48.0	1.5	0.05	<b>0.076</b>	12.5	<b>0.1</b>	0.2	0.1
8	ОЦ-11-ээс ОЦ-13 хүртэл	618,145.8	5.72	0.072	66.0	4.7	0.09	<b>0.108</b>	53.0	<b>0.4</b>	0.6	0.4
9	ОЦ-14-өөс ОЦ-18 хүртэл	578,564.4	5.36	0.069	55.0	3.8	0.09	<b>0.108</b>	46.5	<b>0.3</b>	0.6	0.3
10	ОЦ-18-аас 7 барилга хүртэл	238,969.6	2.21	0.045	30.0	1.3	0.07	<b>0.076</b>	50.2	<b>0.2</b>	0.5	0.2
11	ОЦ-18-аас 8,29 барилга хүртэл	105,347.1	0.98	0.030	65.0	1.9	0.05	<b>0.076</b>	9.7	<b>0.1</b>	0.2	0.1
12	ОЦ-14-өөс ОЦ15 хүртэл	234,247.7	2.17	0.044	70.0	3.1	0.07	<b>0.108</b>	7.6	<b>0.1</b>	0.2	0.1
13	ОЦ-15-аас ОЦ16 хүртэл	211,975.5	1.96	0.042	37.0	1.6	0.06	<b>0.076</b>	39.5	<b>0.2</b>	0.4	0.2
14	ОЦ-16-аас ОЦ17 хүртэл	53,433.4	0.49	0.021	43.0	0.9	0.04	<b>0.057</b>	11.4	<b>0.1</b>	0.2	0.1
15	ОЦ-15-аас 12 дугаартай барилга хүртэл	89,703.0	0.83	0.027	33.0	0.9	0.05	<b>0.076</b>	7.1	<b>0.0</b>	0.2	0.0
	<b>Дүн</b>				<b>662.0</b>							
	<b>НИЙТ ДҮН</b>				<b>1416.0</b>							

### Дулаан хангамжийн шугам сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Хүснэгт 14. Дулаан хангамжийн шугам сүлжээний хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Барилга угсралтын үнэ		Нийт хөрөнгө оруулалт /сая.төг/		
					100м-ийн төсвийн жишиг үнэлгээ /сая.төг/	Инфляци	Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
Дулаан хангамж									
НИЙТ ДҮН				<b>1.416</b>			<b>13,711.8</b>	<b>296.9</b>	<b>14,008.7</b>
<b>I хэлхээ</b>									
1	Дулааны эх үүсвэр өргөтгөх	9.10	Гкал/цаг	1.0	450.0	1.77	7,248.2	217.4	7,465.6
3	Гадна дулааны шугам	Ф250мм	км	0.118	236.88	1.77	494.7	3.3	498.0
4	Гадна дулааны шугам	Ф219мм	км	0.208	204.87	1.77	754.2	9.0	763.2
5	ДХТ-1	3.9 Гкал/цаг	ком	1	517.19	1.77	915.4	11.3	926.7
6	ДХТ-2	5.2Гкал/цаг	ком	1	517.19	1.77	915.4	13.3	928.7
ДҮН /I хэлхээ/				<b>0.326</b>			<b>10,328.0</b>	<b>254.3</b>	<b>10,582.3</b>
<b>II хэлхээ</b>									
1	Гадна дулааны шугам	Ф250мм	км	0.034	236.88	1.77	142.6	0.9	143.5
2	Гадна дулааны шугам	Ф219мм	км	0.067	204.87	1.77	243.0	2.9	245.9
